

Б. Дуламсүрэн Дорнод их сургуулийн БУБС-ийн багш, докторант
duka323@gmail.com

Д. Янжмаа Дорнод их сургуулийн БУБС-ийн багш, магистр
dugaryanjmaa@gmail.com

ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛД ГАЗРЫН ТОСНЫ САЛБАРЫН ЭКОЛОГИЙН АСУУДЛЫГ НӨӨЦ АШИГЛАСНЫ ТӨЛБӨРӨӨР ШИЙДВЭРЛЭХ НЬ

Abstract

Human attitudes to the nature and to its resource are rapidly changing year by year showing negative results because of development of world population, economy and technological advances. The aim of sustainable development is to improve an economy without destroying its natural environment. Unfortunately, we Mongolians and our politicians consider that only way to improve its economy is mining and petroleum. We are using our natural resources immensely and it is harmful to the environment.

So my research is aimed to show how operation of petroleum is affecting to the nature and calculating the payment of natural resource usage which is stored in the local development fund.

Key words: *Tamsag, output, transportation, environment, rehabilitation, economy, society.*

Хураангуй

Дэлхийн хүн амын өсөлт, эдийн засаг, технологийн хөгжлийг даган байгаль орчин түүний нөөц баялагт хандах хүмүүний хандлага хэрэглээ жилээс жилд өөрчлөгдөж олон талын сөрөг нөлөөллийг үүсгэж байна. Тогтвортой хөгжлийн гол зорилго бол байгаль орчноо сүйтгэхгүйгээр эдийн засгаа хөгжүүлэхийг хэлдэг. Гэтэл манай улс эдийн засгийн хөгжлийн гарцаа уул уурхай, газрын тосны салбар гэж үзэн байгалийн нөөц баялагаа шавхаж, хүрээлэн буй орчноо доройтуулан, байгалийн тэнцвэрт байдлыг ихээр алдагдуулж байна.

Тиймээс энэхүү судалгааны ажлаараа газрын тосны олборлолтын үйл ажиллагаа нь байгаль орчинд хэрхэн нөлөөлж байгаа болон орон нутгийн хөгжлийн нэгдсэн санд хуримтлагдсан байгалийн нөөц ашигласны төлбөрийг тооцож гаргахад судалгааны зорилго оршино.

Түлхүүр үг: *Тамсаг, олборлолт, тээвэрлэл, байгаль орчин, нөхөн сэргээлт, эдийн засаг, нийгэм*

Удиртгал

Гро Харлем Брундландын тэргүүлсэн Дэлхийн байгаль орчин, хөгжлийн хорооноос “Өнөөгийнхнөө хэрэгцээ шаардлагыг хангахдаа хойч үеийнхнийхээ хэрэгцээгээ хангах боломжийг алдагдуулахгүй байх хөгжил”¹-ийг тогтвортой хөгжил гэж тодорхойлжээ.

1992 онд болсон Рио Де Жанейрогийн “Даян дэлхийн XXI зууны тогтвортой хөгжлийн хөтөлбөр”-ийн тунхаглалд тогтвортой хөгжлийн тулгын гурван чулууг байгаль орчин, нийгэм, эдийн засаг гэж тодорхойлоод дээрх гурвыг нэгтгэн цогц байдлаар авч үзэн тогтвортой хөгжлийн загварыг боловсруулсан.

Аливаа улс орон өөрийн улсын давуу талыг ашиглан тогтвортой хөгжих хандлагыг баримталж байна. Тиймээс газар доорх баялагаа ашиглан хөрөнгө оруулалгчдыг татах замаар эдийн засгаа хөгжүүлэх явдал байдаг ч байгалийн нөөцийг ашиглахаасаа өмнө улс орны

¹ Уул уурхайн яам, Байгалт орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яам, азийн сан., Тогтвортой хөгжил-байгалийн нөөцийн хариуцлагатай ашиглалт, УБ, 2015 он, Вайслайт ХХК, 11тал

эдийн засагт оруулах үр ашиг, нийгэмд үзүүлэх хувь нэмэр, байгаль орчинд нөлөөлөх олон талт байдлыг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр судлах хэрэгтэй.

Манай улсын уул уурхай, ашигт малтмалын салбар эрчимтэй хөгжиж буй энэ үед Монгол улсын зүүн бүс газрын тосны олборлогч нутаг хэдийнээ болж Тосон уул- XIX талбайд, Тамсагийн –XXI талбайд олборлолт хийгдэж байна. Монгол улс 332,6 сая тн газрын тосны нөөцтэй 92% буюу 306,5 сая тн нөөц Дорнод аймгийн нутаг Тамсагийн сав газраас олборлогдож байгаа хэдий ч, орон нутгийг дэмжих, байгаль орчинг нөхөн сэргээх, нутгийн ард иргэдийн амьдралд бодитой хувь нэмэр оруулж чадахгүй байна.

Газрын тосны олборлолтын үйл ажиллагаа нь байгаль орчинд хэрхэн нөлөөлж байгаль орчныг хэрхэн сүйтгэж байгаа болон газрын тосны салбарын өнөөгийн байдалд тогтвортой хөгжлийн үзэл баримтлалын хэрэгжилт, орон нутгийн хөгжлийн нэгдсэн санд хуримтлагдсан байгалийн нөөц ашигласны төлбөрийг тооцож гаргахад судалгааны зорилго оршино.

Судлагдсан байдал

Судлаач Ө.Одбаяр (2015он) “Байгалын нөөц баялгыг зохистой ашиглах замаар тогтвортой хөгжлийг дэмжих нь” сэдэвт судалгааны ажилдаа байгалийн нөөцийг зохистой ашиглах замаар ирээдүйд хуримтлалыг бий болгон эдийн засгийн өсөлтийг дэмжих нь зүй гэж үзсэн байна.

Мөн эрдэс баялгийн салбарын талаар төрөөс баримтлах бодлогод дэлхий нийтийн тогтвортой хөгжлийн түгээмэл үзэл хандлагын хүрээнд газрын хэвлийн баялагынхаа давуу байдалд тулгуурлан байгаль орчин, эдийн засаг, нийгмийн хөгжлийн тэнцлийг хангасан харилцан ашигтай, ил тод хариуцлагатай, байгаль орчинд ээлтэй дэвшилтэт техник технологи нэвтрүүлэх замаар эдийн засгийн өсөлтийг хангах нь зүйтэй гэж тусгасан байна.

Газрын тосны салбарын байгальд учруулж буй хор уршиг: Эрдсийн түүхий эдийн олон төрлийн баялагийн нэг нь газрын тос. Газрын тос нь олон төрлийн нүүрсустөрөгчдөөс тогтох шингэн, шатах ашигт малтмал юм.²

Байгалийн эрдэс баялаг нь газрын хэвлийд байхдаа агаар усны тэнцвэрийг хадгалан зохицуулж байдаг онцлогтой. Харин олборлолт явуулснаар төрөл бүрийн химийн бодис агаар мандалд тархан байгалийн тэнцвэрийг алдагдуулдаг. Үүний нотолгоо нь уул уурхайн үйлдвэрлэл эрчимтэй явагдаж буй газар нутагт ургамал, ан амьтдын төрөл зүйлийн тоо хэмжээ хорогдож буй явдал. Уул уухайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаа нь дараах сөрөг нөлөөлөл, үр дагавар бүхий өргөн хүрээнд нөлөөлөл үзүүлдэг³. Үүнд:

- Уурхайн ашиглалтын зөвшөөрөлтэй талбайн зам, ус дамжуулах шугам хоолой, усны цооногийн талбай болон үйлдвэрлэлийн барилгын ажлаас үүдэн амьдрах орчин, урт хугацаанд эсвэл бүр мөсөн алдагдах

- Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс тоосжилт үүсч, ургамалын бүрхэвчийг доройтуулах, хогийн ургамал тархах, дуу чимээ ихсэх, тайван бус байдал нэмэгдэх, зэрлэг амьтдын нүүдэлд саад учруулах, амьдрах орчны хуваагдал үүсэх

- Аюултай бодис ба хог хаягдлын асуудлыг зөв зохистой шийдэхгүй тохиолдолд хөрс, ус, агаар бохирдох

- Гүний усны түвшин өөрчлөгдөх буюу татарснаар амьтан ба ургамлын амьдралыг тэтгэдэг усны нөөцөд нөлөөлөх

- Бэлчээр доройтолд орох зэрэг нөлөө үзүүлж байна.

Газрын тосны гадаргын бохирдол: Газрын тосны ордын ус нь ихэнх тохиолдолд бром, иод, ради, стронци, магни болон бусад онцгой ховорт тооцогддог үнэт элементүүдийг их

² www.wikipedia.org

³ Уул уурхайн яам, Байгалт орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яам, азийн сан., Тогтвортой хөгжил-байгалийн нөөцийн хариуцлагатай ашиглалт, УБ, 2015 он, Вайслайт ХХК, 41 тал

хэмжээгээр агуулсан байдаг⁴. Мөн газрын тос олборлолтын практикт техникийн болон байгалийн хүчин зүйлээс шалтгаалан хөрс ямар нэгэн хэмжээгээр газрын тосоор бохирдох явдал түгээмэл гардаг⁵.

Зураг 2: Газрын гадарга дээрх газрын тосоор бохирдсон хөрс



Эх сурвалж: Өглөөний сонин. Сэтгүүлчийн томилолт 003. https://www.youtube.com/watch?v=w_68bMfXKL

Газрын тос тээвэрлэлт: Тамсагийн сав газраас Монгол Улсын хилийн Бичигтийн боомт хүртэл 200км, Тосон уул- XIX талбайгаас Тамсагийн –XXI талбай хүртэл 60 км зайтай⁶. Олборлосон газрын тос тээвэрлэж буй автомашинууд XIX талбайгаас хил хүртэл 260 орчим км зам туулдаг байна.

Зураг 4: Газрын тос тээвэрлэдэг замын байдал



Эх сурвалж: Өглөөний сонин. Сэтгүүлчийн томилолт 003. https://www.youtube.com/watch?v=w_68bMfXKLw

Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс тоосжилт их үүссэнээс болж ургамлын бүрхэвчийг доройтуулж хялгана ургадаг байсан газар хогийн ургамал/шарилж/ ургаж, зэрлэг амьтдын

⁴ Ч.Гүнчин, Ч.Ганхуяг, О.Отгонтуул, И.Сүхбаатар, Ж.Цэвээнжав, Газрын тосны дагалдах уснаас иодидын ба бромидын ионыг анион солилцлолын давирхайгаар шингээж ялган авах боломж, Газрын тос-2014, УБ, 2014 он, 81 тал

⁵ Б.Жавхлан, О.Ариун-Оргил, Тамсагийн сав газрын тосоор бохирдсон хөрс шороог цэвэрлэх арга технологийн асуудалд, Газрын тос-2015, УБ, 2015 он, 242 тал

⁶ П.Очирбат, Монголын газрын тосны судалгааны шинэ үе, УБ., 2013 он Адмон принт ХХК, 106 тал

амьдрах орчинд саад учруулах, амьдрах орчны хуваагдал үүсэн, бэлчээрийн доройтолд орох үндсийг тавьж байна.

Арга зүй


Баримт бичгийн шинжилгээ хийж, статистик аргаар боловсруулалт хийсэн. Судалгаандаа Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Петро Чайна Дайчин Тамсаг ХХК-ийн олборлолтын болон улсын төсөвт төвлөрүүлсэн орлогын мэдээллийг ашигласан.

Нөөц ашигласны төлбөр, түүнийг хуваарилах: Газрын тос, байгалийн хийн нөөц ашигласаны төлбөр буюу роялти нь нөхөн сэргээгдэшгүй байгалийн баялаг ашигласаны төлбөр бөгөөд роялтийг тооцохдоо олборлосон тосны чанараас хамааран тогтоодог.

Газрын тосны тухай хуулийн 31.1-р зүйлд: Газрын тос, байгалийн хийн нөөц ашигласны төлбөрийн хэмжээ нь олборлосон түүхий тос, байгалийн хийн 5-15 хувь байна. Газрын тосны тухай хуулийн 31.3-р зүйлд: Нөөц ашигласны төлбөрийн 30 хувийг тухайн орон нутгийн хөгжлийн нэгдсэн санд, 70 хувийг улсын төсөвт тус тус төвлөрүүлнэ гэж тусгасан байна.

Сүүлийн 5 жилийн газрын тосны олборлолт болон улсын төсөвт төвлөрсөн орлогын харьцуулалт

Дүрслэл 1: Олборлолт болон улсын төсөвт төвлөрүүлсэн орлого



Эх сурвалж: Ц.Цэвээнжав. Монголын газрын тосны салбарын үйл ажиллагааны түүх, өнөөгийн байдал, цаашидын хандлага, газрын тос-2015

Олборлолт болон орлогын хэтийн төлөвөөс харахад газрын нөөц ашигласны төлбөрөөс орох орлого нь цаашид өсөх хандлагтай байгаа нь харагдаж байна. Иймд нөөц ашигласны төлбөр буюу нөхөн сэргээгдэшгүй байгалийн баялаг ашигласны төлбөрийг байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээхэд хэрхэн хуваарилж зарцуулах талаар цаашид анхаарч судлах хэрэгтэй байна.

Үр дүн

Эндээс дүгнэхэд байгаль орчин экологийн тэнцвэрт байдлыг алдагдуулахгүйгээр, эдийн засгаа хөгжүүлэх асуудлыг шийдвэрлэхийн тулд байгалийн баялгийн нөөц ашигласны төлбөрийн зарцуулалтад анхаарах, байгаль орчин нөхөн сэргээлтийн ажлыг тасралтгүй зохион байгуулж ажиллах шаардлага тулгарч байна.

Байгалийн баялагийг байгальд сөрөг нөлөө багатайгаар олборлох, боловсруулах, ашиглах технологийг нэвтрүүлэхэд шинжлэх ухааны үндэслэлтэй хандаж, Үндэсний хөгжлийн цогц бодлогыг хэрэгжүүлэхэд хяналт тавих

Байгалийн баялгаас бий болох орлогыг аль болох ухаалаг зөв зохистой зарцуулах нь эдийн засаг нийгмийн тогтвортой байдлыг хангах үндэс болох юм.

Ном зүй

1. Уул уурхайн яам, Байгалт орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яам, азийн сан., Тогтвортой хөгжил-байгалийн нөөцийн хариуцлагатай ашиглалт, УБ, 2015 он, Вайслайт ХХК,

2. Ч.Гүнчин, Ч.Ганхуяг, О.Отгонтуул, И.Сүхбаатар, Ж.Цэвээнжав, Газрын тосны дагалдах уснаас иодидын ба бромидын ионыг анион солилцлолын давирхайгаар шингээж ялган авах боломж, Газрын тос-2014, УБ, 2014 он

3. Б.Жавхлан, О.Ариун-Оргил, Тамсагийн сав газрын тосоор бохирдсон хөрс шороог цэвэрлэх арга технологийн асуудалд, Газрын тос-2015, УБ, 2015 он

4. П.Очирбат, Монголын газрын тосны судалгааны шинэ үе, УБ., 2013 он Адмон принт ХХК

5. www.wikipedia.org